



**МОНГОЛЫН ТӨМӨР ЗАМ**

**ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ  
ХӨГЖЛИЙН ОНОЛЫН СУДАЛГАА**

**БИЗНЕС ХӨГЖИЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН МЭРГЭЖИЛТЭН  
Д. ОТГОНЧИМЭГ**

**УЛААНБААТАР ХОТ**

**2022.04.30**

## АГУУЛГА

ХУРААНГУЙ.....	3
УДИРТГАЛ .....	3
Монгол улсын төмөр замын салбарын өнөөгийн байдал .....	5
1. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ.....	6
1.1 Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д Төмөр зам, логистикийн хөгжлийн талаар .....	9
1.2 Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого болон бусад төмөр замын хөгжлийн төсөл хөтөлбөр.....	11
1.3 Шинэ төмөр зам төсөл болон бусад бодлого .....	12
2. UN GLOBAL COMPACT MANAGEMENT MODEL-НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ ГЛОБАЛ КОМПАКТ МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР .....	13
Тогтвортой байдлын гүйцэтгэлийг хэмжих .....	16
Тогтвортой байдлын тайлагнах.....	16
3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ.....	17
Институцын онолын тойм .....	17
ДҮГНЭЛТ .....	19
НОМ ЗҮЙ.....	20

## ХУРААНГУЙ

“Тогтвортой хөгжил”-ийн загвар нь байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийн загвар юм. Бизнесийн байгууллагуудын тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулах, үйл ажиллагаа явуулахад нь туслах менежментийн аргыг Делойтте ЛЛС<sup>1</sup>-ын менежментийн чиглэлээр мэргэшсэн, нийгмийн шинжлэх ухааны тэргүүлэх эрдэмтэд боловсруулсан байдаг. Бизнесийн байгууллагын тогтвортой байдлын менежментийн хэрэгжилтийн загварчлал (UN Global Compact Management Model) (НҮ-ний Глобал Компакт Менежментийн загвар) нь корпорацийн тогтвортой байдлын стратегийг албан ёсоор тодорхойлох, үнэлэх, хэрэгжүүлэх, хэмжих, дамжуулах үйл явцыг бүх түвшинд явуулахад компаниудыг удирдан чиглүүлдэг. Энэхүү загвар нь олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн, ойлгомжтой менежментийн практик дээр үндэслэсэн бөгөөд компанийн тогтвортой байдлын гүйцэтгэлийг загварчлах зорилготой. Мөн оролцогч талууд, нийгмийн сайн сайхны төлөө, компаниудын засаглалыг сайжруулах, гүйцэтгэлийн үр дүнг дээшлүүлэх, үнэ цэнийг бий болгох, тогтвортой урт удаан оршин тогтноход зориулагдсан. Энэхүү судалгаагаар төмөр замын салбарын тогтвортой хөгжлийг үнэлэх шалгуур үзүүлэлтүүдийг олон улсын түвшинд тодорхойлсон байдлын чанарын (бичиг баримтын) буюу онолын судалгааг хийсэн болно.

**Түлхүүр үг:** Тогтвортой хөгжил, (UN Global Compact Management Model) - менежментийн загвар, төмөр замын тогтвортой хөгжил, шалгуур үзүүлэлт

## УДИРТГАЛ

Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны цар хүрээ нь улам их баяжиж хувьсан, хөгжлийн тэргүүлэх загвар болон хэрэгжиж байна. Улмаар тогтворгүй байх шалтгааны зарим шинж чанар, нөлөөлөх хүчин зүйлсийг одоо хүртэл хэлэлцсээр байна. Эдгээр асуудлуудыг засгийн газрын зарим институт, судалгааны байгууллагууд, бизнесийн ертөнц тэрч байтугай хувь хүмүүс бодитоор хүлээн авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлага бий болсон.

Монгол Улс Тогтвортой хөгжлийн асуудлуудыг тусгасан урт хугацааны бодлогыг баталж, тогтвортой хөгжлийн зорилгыг нутагшуулсан анхны улсуудын нэг юм. Тогтвортой хөгжихөд тулгамдаж байгаа сорилт, бэрхшээлүүд нь тулгамдаж буй асуудал болж байна.

- Монгол улс нь бодлогын төдийгүй шууд хянах боломжгүй бусад хүчин зүйлээс (түүхий эдийн үнийн хэлбэлзэл, цаг уурын өөрчлөлтөөс үүдэлтэй байгалийн гамшгийн давтамж, дэлхийн хөгжлийн тодорхой бус байдал зэрэг) шалтгаалан эмзэг хэвээр байна.

---

<sup>1</sup> Deloitte LLC нь 2000 онд байгуулагдсан хувьцаа эзэмшигчид болон бусад оролцогч талуудын үнэт зүйлийг бий болгох, хамгаалах чиглэлээр ажилладаг дэлхийн олон улс оронд зөвөлгөө өгдөг.

- Хөгжлийн ялгаатай байдал газар авсан: Ядуурал, тэгш бус байдал, нийгмийн үйлчилгээ, зохистой хөдөлмөр эрхлэлтийн боломж
- Бодлогын болон институцуудын уялдаагүй байдал (ҮХГ, 2019)<sup>2</sup>

Тогтвортой байдлыг хангахад чиглэсэн ахиц дэвшил удаашралтай, мөн хяналт, шинжилгээний загварыг оройтож хэрэгжүүлж эхлээд байгааг эрдэмтэд хүлээн зөвшөөрсөн байдаг. Тогтвортой байдлыг хэмжих хэрэгтэй юу? НҮБ-ын тайлангуудад сүүлийн хорин жил тогтвортой байх явц яагаад ийм удаашралтай байна вэ? гэдгийг санал нэгтгэйгээр цохон тэмдэглэсэн байх юм. Өөрөөр хэлбэл энэ талаар тогтворгүй, өөрчлөгдөхгүй байгаа учир шалтгааныг дэлхий дахинд шинжлэх ухааны бүтээлүүдэд бас хүлээн зөвшөөрөөд байна (Gloria Guevara Manzo, 2019).

Монгол улсын хувьд тогтвортой хөгжихөд тулгамдаж байгаа гол саад бэрхшээлүүдийг ҮХГ-ын (2017) судалгааны тайланд дараах байдлаар илтгэжээ. Үүнд:

1. Бодлогын уялдаа, зохицуулалт сул:
  - Үндэсний хөгжлийн цогц бодлого, улс төрийн намуудын хөтөлбөр болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн уялдаа сул,
  - Бодлогын баримт бичгүүд харилцан уялдаагүй, хэрэгжилт хангалтгүй, залгамж чанар байхгүй,
  - Боловсруулалт хангалтгүй, залгамж чанар байхгүй,
2. Нэгдсэн тогтолцоо байхгүй:
  - Бодлого төлөвлөлтийн институцын тогтолцоо боловсронгуй бус, чадавхи сул,
  - Төлөвлөлтийн үе шат тодорхойгүй,
  - Төлөвлөлт, хэрэгжүүлэлт, хяналт-шинжилгээ-үнэлгээ, хариуцлагын тогтолцоо бүрдээгүй,
3. Санхүүжилтйн эх үүсвэр тодорхойгүй, тооцоолол дутуу:
  - Улсын болон орон нутгийн төсөв, гадаад, дотоод хөрөнгө оруулалт, бонд, концесс, бусад эх үүсвэр
4. Бодлого боловсруулах арга зүй төлөвшөөгүй
  - Бодлогын баримт бичиг боловсруулахад шаардлагатай судалгаа хийх, төлөвлөлтийн шатанд санхүүгийн эх үүсвэрийн үндэслэл, тооцоо дутуу, нийгэм эдийн засгийн үр дагавар, хүрэх үр дүнг үнэлэх, тодорхойлох арга аргачлал тодорхойгүй

Үүний гол шалтгаан нь бодлого төлөвлөлтийн эрх зүйн орчин төлөвшөөгүй гэж дүгнэжээ. Улс орны дунд болон урт хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийг төрийн мэргэшсэн байгууллагууд, их дээд сургууль, шинжлэх ухааны академийн эрдэмтэн, судлаачид, салбарын мэргэшсэн хүмүүс, мэргэжлийн холбоод, улс төрийн намууд болон иргэний нийгмийн төлөөллийн оролцоотой боловсруулдаг тогтолцоог бий болгох шаардлагатай байна. Үүний тулд Монгол Улсын Үндэсний хөгжлийн газрын дэргэд бие даасан бодлогын судалгааны хүрээлэнг байгуулах шаардлагатай байна.

Тогтвортой хөгжлийн менежмент нь аль ч салбарт тогтвортой хөгжихөд нөлөөлж байгаа хүчин зүйлсийг тогтмол хянаж, засан сайжруулж, урьдчилан сэргийлэх тасралгүй үргэлжлэх үйл явц юм (Butler.2015).

<sup>2</sup> ҮХГ (2019) UN. SDG Open day. Илтгэл. Улаанбаатар

Энэ бүхнээс дүгнэн үзвэл салбаруудын тогтвортой хөгжлийг тоо хэмжээний механик өсөлтөөр юм уу, эсвэл зах зээлийн хуулиар өөрөө хөгжинө хэмээн урсгалаар хандах бус, харин салбарын тогтвортой хөгжлийн бодлого, төлөвлөлт, гүйцэтгэлийг олон улсын хэмжүүрээр тооцсон шинжлэх ухааны үндэстэй суурь судалгааны үндэстэй хөгжүүлэх нь үр нөлөөтэй.

Тогтвортой хөгжлийн үйл ажиллагааны цар хүрээ нь улам их баяжиж хувьсан, хөгжлийн тэргүүлэх загвар болон хэрэгжиж байна. Эдгээр асуудлуудыг засгийн газрын зарим институт, судалгааны байгууллагууд, бизнесийн ертөнц тэрч байтугай хувь хүмүүс бодитоор хүлээн авч үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

### Монгол улсын төмөр замын салбарын өнөөгийн байдал

Дэлхийн эдийн засгийн форумас 2 жил тутам гаргадаг тайланд Монгол улсын төмөр замын салбарын өрсөлдөх чадварын үзүүлэлтээр 2018 онд 137 орноос 101-р байр эзэлжээ. Үнэлгээг 1-7 оноогоор үнэлснээс Монгол улс 3.9 оноогоор үнэлэгдсэн байна. Үүнд:

Төмөр замын өрсөлдөх чадварын гол 12 шалгуур үзүүлэлтээс харуулбал:

- Институтц 4.1 (108)
- Дэд бүтэц 3.1 (108)
- Макро эдийн засгийн орчин 4.4 (89)
- Эрүүл мэнд ба суурь боловсрол 5.6 (85)
- Хөдөлмөрийн зах зээлийн үр нөлөө 4.2 (68)
- Техникийн бэлэн байдал 4.2 (74)
- Инноваци 3.0 (101)
- Зах зээлийн хэмжээ 3.0 (104)
- Бизнесийн боловсронгуй байдал 3.3 (123)
- Дээд боловсрол ба сургалтын үр нөлөө 4.5 (65)
- Бараа бүтээгдхүүний зах зээлийн үр нөлөө 4.0 (111)
- Санхүүгийн зах зээлийн хөгжилд нөлөөлөх үр нөлөө 3.0 (129)

Дээрх үзүүлэлтүүд бусад улс орнуудтай харьцуулахад дунджаас доогуур үнэлэгдсэн байна. Түүнчлэн Монгол улсын төмөр замын салбарын эдийн засгийн өнөөгийн үзүүлэлт (2021 оны байдлаар):

- Төмөр замын тээврийн орлого 771,201.12 сая.төгрөг ( ДНБ-ын 0,% )
- Тээсэн ачаа 31,193.20 мян.тн
- Ачаа эргэлт 18,390.36 сая.тн.км
- Дотоодод болон гадаадад тээвэрлэгдсэн ачаа 23,595.03 мян.тн
- Зорчигчид 361.01 мян.хүн
- Салбарын ажилчид 16671 (2020 он) ГТХЗНТ-ийн мэдээлэл. “УБТЗ” ХНН, “МТЗ” ТӨХК, “Болд төмөр ерөө гол” ХХК-ийн ажилчдын мэдээлэл орсон болно.

Зураг 1. Монгол улсын төмөр замын тээврийн орлогын харьцуулалт



Эх сурвалж: ҮСХ, 2022

## 1. ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

“Sustainable” “Sustain+able”/тэмдэг нэр/ гэдэг үгийг толь бичигт дараах байдлаар тайлбарласан байна. (Oxford University)

1. Тодорхой хувь хэмжээ, түвшинтэй байх чадвар;
  - a. Эдийн засгийн тогтвортой өсөлт-‘sustainable economic growth’.
  - b. Байгалийн нөөц шавхагдахаас зайлсхийж экологийн тэнцвэрийг хадгалах-‘Conserving an ecological balance by avoiding depletion of natural resources’.
2. Дэмжих, хамгаалах чадвартай байх; сайн боловсролын туршлагын дэмжсэн тодорхойлолт ‘sustainable definitions of good educational practice’.
3. Үйл ажиллагаа, үйл явцыг хадгалах ба үргэлжлэх чадвар; хоёр улсын хоорондын тууштай тохиролцоо ‘a sustainable negotiation between the two countries’
4. Батлах, бэхжүүлэх чадвар; батлагдсан шийдвэр ‘a sustainable decision’.
5. Үндсэн хэрэгцээ ба хүрэлцээтэй нөөц, баялагыг дэмжих чадвар; хүрэлцээтэй амьдрал ‘a sustainable life’

“Sustainable”-тулхтай, тууштай, нөхөн сэргээгдэх; экологийн ухагдхуунд, тогтвортой, тууштай; эдийн засгийн ухагдхуунд тус тус хэрэглэгддэг (Оxford Монсудар )

“Sustainable development” - /нэр үг/ байгалын нөөцийг шавхахгүйгээр эдийн засгийн хөгжлийг удирдах, хүрээлэн буй орчин гэсэн үзэл санааны хөтлөгч, хөгжлийг дэмжих олон улсын бодлогогэж тодорхойлсон байна (Oxford University, 2020)

Монгол Улсад өнөөдөр тогтвортой хөгжил гэдэг үгийн утгаар бодлогын баримт бичигт албан ёсоор хэрэглэж байна.

1972 оны 6-р сарын 5-16-ны өдрүүдэд Стокгольм болсон НҮБ-ын Ерөнхий Ассемблейгаас олон улсын тогтвортой хөгжлийн анхны “Хүн төрлөхтөн ба Байгаль орчин” чуулга уулзалтыг зохион байгуулж, тогтвортой хөгжлийн тунхаглал болон хүрээлэн буй орчны хөгжлийн 26 зарчмыг баталсан. Уг хурал дээр “Хүний үйл ажиллагаа нь байгаль орчинд хор хохирол учруулж байгаа бөгөөд энэ нь манай гаригийн ирээдүйд заналхийлж байна” гэж цохон тэмдэглэжээ.

1987 онд Хөгжил ба хүрээлэн буй орчны талаарх Даян дэлхийн Комисс Брундтландын Комиссын тунхаглал буюу “Манай нийгмийн ирээдүй” нэртэй баримт бичгийг батлан гаргаснаар Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын үндсэн зарчмууд анх удаа албан ёсоор томъёологдсон гэж үздэг. Чухам энэ үеэс тогтвортой хөгжил бол байгалийн баялаг, технологийн хөгжил, хөрөнгө оруулалт, засаглалын өөрчлөлтийг ашиглан одоо болон ирээдүйнхээ төлөө эрэлт хэрэгцээг хохироохгүйгээр нийгэм бүхэлдээ хөгжих үйл явц гэсэн ойлголт өргөн хүрээнд хэрэглэгдэх болсон. Хүрээлэн буй орчныг доройтуулахгүйгээр хүний сайн сайхан аж байдлыг нэмэгдүүлэх нь “Тогтвортой хөгжил”-ын гол агуулга аж.

“Хөгжил” нь нийгмийн эрэлт хэрэгцээг хангахуйц эдийн засгийн өсөлт (НҮБ, 2005) ба богино, дунд, урт хугацааны сайн сайхан байдал, ирээдүй хойч үеийн амьдралд аюул учруулахгүйгээр өнөөгийн хэрэгцээг хангах. (FAO) Энэ ойлголт нь эдийн засаг байгаль орчныг давхцуулан хүн ба дэлхий ертөнцийн урт хугацааны тогтвортой хөгжил дэвшлийг илэрхийлдэг (Budowski, 1976). “Хөгжил” гэдэг нь хэдхэн гэр бүл, хүнийг баян болгохыг хэлэхгүй. Хөгжил бол нийгэм, эдийн засгийн нааштай суурь өөрчлөлт, ядууралгүй, нийгмийн халамж бүхий, хүн бүрийн өөрийн амьдарлыг зохион байгуулах нөхцөл бүрдсэн байдлыг хэлнэ. Ингэж байж даяарчлал хүнлэг, чанартай болно гэж эрдэмтэд үздэг (Joseph, 1999). Эдийн засгийн үйл ажиллагаанаас хамааралтай хүрээлэн буй орчны бодит хэмжээ хязгаар, эдийн засгийн өсөлтөөр нийгмийн сайн сайхныг хангах гэсэн гурван хүчин зүйлээс хамааралтай “өсөлтийн хүрээ хязгаар” гэсэн ерөнхий маргаантай шүүмжлэлт санаанууд 1970 оноос анх бий болжээ (Ekins, 1993).


1992 оны зун “Дэлхийн чуулга уулзалт” гэж нэрлэгддэг “НҮБ-ын Рио Жанейро дахь хүрээлэн буй орчин, хөгжлийн талаархи” бага хурал дээр “Тогтвортой хөгжил” гэсэн нэр томъёог хэрэглэж, дараах байдлаар тодорхойлжээ. Тогтвортой хөгжил гэдэг нь ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээнд хохирол учруулахгүйгээр өнөөдрийнхөө хэрэгцээг хангаж байхыг тогтвортой хөгжил гэж үзнэ (Brundthland, 1987).

НҮБ-ын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг Брундтландын комисс “Манай ирээдүй” (1987 он) тайландаа энэхүү үзэл баримтлал нь “хүмүүний нийгэмлэгийн тогтвортой хөгжил” хэмээх нэр томъёог өргөн ашигласны үр дүнд НҮБ-ын хүрээнд цаашдын хөгжлөө олсон байна. Тогтвортой хөгжлийн хүчин зүйл нь хүний амьдралын чанарыг сайжруулж, биологийн, нийгмийн, эдийн засгийн, соёлын, улс төрийн, эд материалын болон экологийн нөхцөл байдлыг тооцоолон хүний нөөцийн

хөгжлийг өөртөө агуулдаг учраас энэ үзэл хандлага богино хугацаанд нийтэд хүлээн зөвшөөрөгджээ. (Чулуунбаатар.Г, 2019)

НҮБ-с баталсан ТХЗ-ууд нь хүмүүн төрлөхтөн, эх дэлхий, хөгжил цэцэглэлт, энх тайван, хамтын ажиллагаа гэсэн гурван тулгуурт үндэслэсэн дэлхийн улс бүрт, хөгжлийн гадна хэнийг ч үлдээлгүй хүн бүрийн оролцоог хангах цогц 17 зорилтыг дэвшүүлж хэрэгжилтийг хянах шалгуур үзүүлэлтийг боловсруулжээ.

Зураг 2. Тогтвортой хөгжлийн эдийн засгийн загвар



“Тогтвортой хөгжил”-ийн загвар: Байгаль орчны эрсдэл, доройтлыг багасгахын зэрэгцээ хүний сайн сайхан байдал, нийгмийн тэгш хүртээмжтэй байдлыг сайжруулах зорилго бүхий эдийн засгийн загвар юм.

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 30 жилийн өмнө төрсөн (Telfer, Wall, 1996). Байгаль орчны асуудал, байгалийн нөөцийн хямрал нь ялангуяа эрчим хүчтэй хамааралтай. 2015 оны 9 дүгээр сард НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 70 дугаар чуулган болж, Дэлхийн тогтвортой хөгжлийн 2030 хөтөлбөрийг нийт 17 зорилго, 169 зорилт, 244 шалгуур үзүүлэлттэй батлан гаргасны дагуу Монгол Улсын Их Хурал 2016 оны 19 дүгээр тогтоолоор Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 (МУТХҮБ-2030)-ыг баталсан билээ.

Зураг 3. Тогтвортой хөгжлийн Гурван гол хүчин зүйл





## 1.1 Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д Төмөр зам, логистикийн хөгжлийн талаар

Монгол улсын тогтвортой хөгжлийн зорилтууд :

- **Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилт:** Эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть-хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлнэ.
- **Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт:** Жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэнэ.
- **Байгаль орчны тогтвортой хөгжлийн зорилт:** Байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг сайжруулах үндэс болно.

Зураг 4. МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлалын бүтэц

## МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛЫН БҮТЭЦ

Монгол улс 2030 онд нэг хүнд ногдох орлогоороо дунд орлоготой орнуудын тэргүүлэх эгнээнд хүрсэн тогтвортой өсч байгаа эдийн засгийн олон салбартай, нийгмийн хүрээнд дундаж болон чинээлэг давхрага давамгайлсан, экологийн тэнцвэртэй байдлыг хадгалсан, тогтвортой ардчилсан засаглалтай улс болно.



“Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ын Зорилт 3. Эдийн засгийн өсөлтийг хангах зам, тээвэр, ложистикийн сүлжээг хөгжүүлнэ.

**I үе шат (2016-2020):** Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр ложистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж, Ухаа худаг–Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх.

**II үе шат (2021-2025):** Хөдөө аж ахуй, аж үйлдвэр, уул уурхайн салбарт түшиглэсэн тээвэр ложистикийн төвүүдийг барьж ашиглалтад оруулах, тээврийн шинэ төрлүүдийг хөгжүүлэх, улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 800 км-ээр нэмэгдүүлж, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж дуусгах, бүсүүдийн төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх.

**III үе шат (2026-2030):** Тээвэр ложистикийн шинэ төвүүдийг хөгжүүлж, улсын болон олон улсын чанартай авто замын уртыг 470 км-ээр нэмэгдүүлж, бүсүүдийн төмөр замыг барьж дуусгах зорилтуудыг тусгасан байна.

Дээрх зорилтуудыг батлахдаа 2010 онд УИХ-с баталсан Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлогод уялдуулсан байдаг.

## 1.2 Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого болон бусад төмөр замын хөгжлийн төсөл хөтөлбөр

Монгол Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ыг баталсан бөгөөд энэхүү бодлогын баримт бичигт Монгол Улсад ойролцоогоор 5683,5 км төмөр замын суурь бүтцийг 3 үе шаттайгаар барихаар шийдвэрлэсэн. Мөн тус тогтоолоор эхний ээлжинд баригдах төмөр замын бүтээн байгуулалтын ажлыг 2010 онд багтаан эхлүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын зорилго нь: Төмөр замын тээх, нэвтрүүлэх чадварыг нэмэгдүүлэх, ирээдүйд өсөн нэмэгдэх тээвэрлэлтийн эрэлт хэрэгцээг үр дүнтэй, найдвартай хангахад чиглэсэн үр ашигтай үндэсний төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээг өргөжүүлж, улмаар улс орны дамжин өнгөрүүлэх чадавхийг дээшлүүлэн, салбарын эрх зүйн орчин, бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, ашигт малтмалын томоохон ордуудыг ашиглах, тэдгээрийн бүтээгдэхүүнийг экспортлох болон боловсруулан экспортолж улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийг хурдасгах, ирээдүйн тогтвортой хөгжлийг хангахад оршино.

Зураг 5. Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогоор барих төмөр зам



Эх сурвалж: Алсын хараа-2050(2018).

### **Бодлогын хүрээнд шийдвэрлэх зорилт:**

- Төмөр замын сүлжээ, суурь бүтцийг өргөжүүлэх чиглэлийг улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлага, улсын батлан хамгаалах болон аюулгүй байдлыг

хангах, нийтийн эрх ашиг, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахтай уялдуулан тогтоох;

- ОХУ, БНХАУ-ын төмөр замын тээврийн сүлжээг ашиглан гуравдагч зах зээлд хүрэх худалдаа, тээврийг хөнгөвчилсөн шинэ замнал /маршрут/-ыг бий болгон далайн боомтуудад гарцтай болох;
- Төмөр замын нэвтрүүлэх чадварыг дээшлүүлж, уул уурхайн бүтээгдэхүүн, дамжин өнгөрүүлэх ачаа тээвэр болон экспорт, импортын ачаа эргэлтийг үр дүнтэй хангах тээвэрлэлтийн оновчтой зохион байгуулалт бүхий төмөр замын дотоодын нэгдсэн сүлжээтэй болох;
- Ашигт малтмалын томоохон ордуудтай төмөр замаар холбогдсон аж үйлдвэрийн цогцолбор байгуулах, ашигт малтмалыг боловсруулж нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх, эдийн засгийн эргэлтийг хангах, экспортыг дэмжих замаар дотоодын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх;
- Төмөр замын салбарт бүтцийн шинэчлэлт хийж, төмөр замын тээврийн салбарын менежментийг боловсронгуй болгох;
- Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрүүлэх боломжийг ашиглан төмөр замын сүлжээг өргөжүүлэх чиглэлийг тогтоосны үндсэн дээр Ази-Европыг холбосон өрсөлдөх чадвартай дамжин өнгөрүүлэх тээврийн шинэ замнал /маршрут/ бий болгох;
- Ажлын байр бий болгох, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих, худалдан авагч улсуудтай олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх.

### 1.3 Шинэ төмөр зам төсөл болон бусад бодлого

Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн 121 дүгээр тогтоолоор “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-ын I болон II үе шатны төмөр замын суурь бүтцийг Улсын эдийн засаг, нийгэмд онцгой ач холбогдолтой төмөр замын суурь бүтэц” гэж үзэж нэгдсэн удирдлага, зохион байгуулалттайгаар цогцоор нь барьж байгуулах зорилгоор суурь бүтэц барих тусгай зөвшөөрлийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон бөгөөд төмөр замын төслүүдийг гадаад, дотоодын хөрөнгө оруулагч нартай хамтарсан тусгай зориулалтын компани байгуулах замаар хэрэгжүүлэхийг даалгасан. Уг даалгаврын дагуу

Засгийн газрын 2013 оны 28 дугаар тогтоолоор, “Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого”-д заасан I, II үе шатанд барих төмөр замын суурь бүтцийн “барих-ашиглах-шилжүүлэх” концессийг “Монголын төмөр зам” ТӨХК-д олгосон.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдрийн "Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай Улсын Их Хурлын 2010 оны 32 дугаар тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай" 82 дугаар тогтоолоор 1."Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2010 оны 06 дугаар сарын 24- ний өдрийн 32 дугаар тогтоолын хавсралтын "Гурав"-ын 3.2.4 дэх заалтын "нийт 1900 орчим км" гэснийг "нийт 3100 орчим км" гэж, 3.2.4.1 дэх дэд заалтын "Нарийнсухайт-Шивээхүрэн - 45.5 км;" гэснийг "Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн-1255 км;" гэж тус тус өөрчилсөн.

Монгол Улсын Их Хурлын 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого батлах тухай” 106 дугаар тогтоолд:

- Хилийн боомтуудыг төмөр замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлнэ;
- Баруун болон зүүн босоо тэнхлэгийн төмөр замын төслүүдийг эрчимжүүлнэ;
- Шинээр Чойбалсан-Хөөт-Бичигт, Сайншанд-Баруун-Урт-Хөөт, Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн төмөр замын сүлжээг байгуулна гэж тус тус заасан.

Ерөнхий сайдын 2022 оны 01-р сарын 11-ны өдрийн “Шинэ сэргэлтийн бодлого хэрэгжүүлж, хөгжлийн төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай” 01 тоот албан даалгаварт Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн төмөр зам, Бичигт-Хөөт, Хөөт-Чойбалсан чиглэлийн төмөр замыг “Монголын төмөр зам” ТӨХК-ийн удирдлага дор хэрэгжүүлэх боломжийг судалж, саналаа Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг даалгасан.

Зураг 6. Шинэ сэргэлтийн бодлогоор ашиглалтад оруулах боомтууд



## 2. UN GLOBAL COMPACT MANAGEMENT MODEL-НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ ГЛОБАЛ КОМПАКТ МЕНЕЖМЕНТИЙН ЗАГВАР

Тогтвортой хөгжлийн менежмент нь компаниудад цаг хугацааны явцад тогтвортой үйл ажиллагааны хэрэгжилтийг өндөр түвшинд хүргэхийн тулд туслах зорилготой манлайллын практик удирдамжийг өгдөг динамик давталттай, тасралтгүй үргэлжлэх үйл явц юм. (Зураг 1, 2-ийг үз). Загвар нь жил бүр стратеги боловсруулахад хэрэглэгдэх ба тасралтгүй сайжруулах уяан хатан тойрог хэлбэртэй.

Зураг 7. UN Global Compact Management Model  
(НҮ-ний Глобал Компакт Менежментийн загвар)



Эх үүсвэр: UN and Deloitte Consulting LLP (2010). Framework for Implementation.

Загварын алхам бүр нь тогтвортой байдлын хүчин чармайлтыг хангаж өгөх үүрэгтэй ба түүний үр өгөөжийг тооцоход хэрэглэгдэнэ. Үүнийг тооцоолсоор оролцогч талуудад үнэлгээний үр дүнг мэдээлэх шаардлагатай байдаг.

Компанийн бүтэц, үйл ажиллагааны цар хүрээнээс хамаараад хувьцаа эзэмшигчид болон өсөн нэмэгдэж буй оролцогч талуудын ашиг сонирхолыг хамгаалж компанийн удирдлага (ТУЗ болон ижил төстэй удирдлага) болон ажилтнуудын хоорондын тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалттай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг компанийн засаглал хангана.

*Хүснэгт 1. Тогтвортой хөгжлийн менежментийн үйл явцын алхамуудын тодорхойлолт*

<p><b>1.ТӨЛӨВЛӨХ</b></p>	<p>НҮБ-ийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд GC-ын 10 зарчмуудыг багтаасан үйл ажиллагааны стратегийг боловсруулах</p>	<p>Энэ алхамыг оролцогч талуудтай хамтран хэрэгжүүлнэ. Ялангуяа компанийн стратеги, соёл, өдөр тутмын үйл ажиллагаандаа GC-ын 10 зарчмуудыг дэмжиж ажиллах засаглалын ил тод байдлыг хангах компаний бүтэц бий болгох.</p>
--------------------------	---	--

<p><b>2.ҮНЭЛЭХ</b></p>	<p>ГС зарчмуудын хүрээг хамарсан эрсдэл болон боломжуудыг үнэлэх</p>	<p>НҮБ-ын зорилгыг дэмжиж, ГС зарчмуудын хүрээг хамарсан компанийн санхүүгийн болон санхүүгийн бус үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө, эрсдэл, боломжуудыг үнэлэх байдлаар үйл ажиллагааны зорилго, стратеги, бодлогыг боловсронгуй болгох.</p>
<p><b>3.ТОДОРХОЙЛОХ</b></p>	<p>Зорилго, стратеги, бодлого тодорхойлох</p>	<p>Эрсдэл, боломж, нөлөөллийн үнэлгээг үндэслэн компани нь үйл ажиллагааныхаа зорилго, зорилтуудаа тодорхойлж, бодлого, хэрэгжүүлэх арга зам, хөтөлбөрийг боловсронгуй болгох,</p>
<p><b>4.ХЭРЭГЖҮҮЛЭХ</b></p>	<p>Компаний стратеги хэрэгжүүлэх,бодлогоор дамжуулан компанийн үнэ цэнийн гинжин хэлхээг бий болгох</p>	<p>Компани нь үндсэн үйл ажиллагаандаа тогтмол тохируулга хийх, ажилчдыг сургах, чадавхижуулах, ханган нийлүүлэлтийн сүлжээ түншүүдтэй стратегиа хэрэгжүүлэхэд хамтран ажиллах</p>
<p><b>5.ХЭМЖИХ</b></p>	<p>Зорилгын ахиц дэвшил хүрэх нөлөөллийн хэмжилт, мониторинг хийх</p>	<p>Байгууллага нь менежментийн дүн шинжилгээ хийх ба гүйцэтгэлийн үйл явцын алхамуудыг хянах, гүйцэтгэлийг сайжруулахын тулд системийн тохируулга хийнэ.</p>
<p><b>6.ТАЙЛАГНАХ</b></p>	<p>Оролцогч талуудад стратегийн гүйцэтгэлийн талаарх тогтмол мэдээлж тайлагнах</p>	<p>Энэ шатанд компанийн зорилгын биелэлт болон стратегийн гүйцэтгэлийг оролцогч талуудад мэдээлэх, гүйцэтгэлийг</p>

		тасралтгүй сайжруулах арга замуудыг тодорхойлох.
--	--	--

Судалгааны хүрээнд дээрх менежментийн зургаан үе шатаас хэмжих, тайлагнах үе шатуудыг судалгааны онолын суурь болгосон тул илүү дэлгэрэнгүй тайлбарлалаа.

#### Тогтвортой байдлын гүйцэтгэлийг хэмжих

Байгууллагын зорилгод хүрэхийн тулд стратегийн гүйцэтгэлд дүн шинжилгээ хийж, менежментийн системийн тохиргоог хийх үе шат нь гүйцэтгэлийг хэмжих, хянах үйл явц юм. Энэ үе шатанд гүйцэтгэлийн хэмжээг үнэлж, тодорхойлж, гүйцэтгэлийг сайжруулах тохиргоог хийдэг ба зорилгыг биелүүлэх дэвшилд хүргэх үйл ажиллагаа явагдна.

Энэхүү үйл ажиллагааг явуулахдаа гүйцэтгэлийг хэмжих арга техник хэрэглэх ба үүнд мэдээлэл цуглуулах цаг хугацаа шаардагддаг. Гүйцэтгэлийн нарийвчилсан хэмжүүрүүд ашиглахаас гадна бусад мэдээллийн системийг ашигладаг. Шаардлагатай мэдээллийг цуглуулахдаа доороос дээш чиглэнэ. Тогтвортой үйл ажиллагаатай холбоотой гарах үнэ цэнийн гинжин хэлхээний ойлголт дээр тулгуурлана.

Тогтвортой байдлын мэдээллийг цуглуулахдаа үйл ажиллагааны тайлан ба мэдээллийн өгөгдөл, баазуудыг ашиглана. Бүх тасаг хэлтэс, ажилчид, харилцагч талуудыг хамруулсан өргөн хүрээний мэдээллийн баазыг ашиглана. Тогтвортой байдлыг тайлагнахын өмнө тогтвортой байдлыг хэмжиж, тохируулга хийж хянах үйл явц нь байгууллагын тогтвортой хөгжлийн зорилгод хүргэхэд нөлөөлдөг үйл ажиллагааны систем байдаг. Энэхүү гүйцэтгэлийн мэдээлэл цуглуулах, хэмжих үйл ажиллагаа нь тогтвортой байдлыг тайлагнах, санхүүгийн болон хөрөнгө оруулах шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой менежментийн үе шат болдог.

#### Тогтвортой байдлын тайлагнах

Тогтвортой байдлыг тайлагнах үе шатанд хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигч бусад оролцогч талуудад стратегийн гүйцэтгэлийн мэдээллийг боловсруулан хүргэх үйл явц.

Байгууллагын стратегийн гүйцэтгэл нь жил бүр санхүүгийн тайланд нэгтгэгдэн тусгадаг. Энэхүү тайлан нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой байдлын үндсэн үйл ажиллагааны онолын хүрээ, зарчим дээр тулгуурлан явагддаг. Тогтвортой байдлын тайлан нь гадаад мэдээлэл хэрэглэгчдээс орон нутгийн засаг захиргаа, төрийн байгууллага) стратегийн гүйцэтгэлийн үр дүнгийн дүгнэлт, болон ирээдүйн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн талаарх санал зөвлөмж авахад зориулагддаг. Байгууллага нь тогтвортой байдлын талаарх оролцогч талуудын санал зөвлөмж, шүүмжлэлийг хүлээн авч үйл ажиллагаандаа тусгасанаар байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй сайжирч, байгууллагын нэр хүнд, итгэх итгэл, цаашид тогтвортой хөгжихөд чухал ач холбогдолтой байдаг.

Санхүүгийн тайлан мэдээ нь байгууллагын тогтвортой байдлын стратегийн зорилго, түүний гүйцэтгэлийг гуравдагч этгээдээр баталгаажуулсан, итгэл үнэмшилтэй байхаас гадна ТУЗ-ын хүлээн зөвшөөрсөн хамгийн чухал, хамгийн сүүлийн үеийн нийтээр хэрэглэгдэж байгаа баримт бичиг болж байна.



### 3. ТӨМӨР ЗАМЫН САЛБАРЫН ТОГТВОРТОЙ БАЙДАЛ

#### Институцын онолын тойм

Олон улсын ачаа тээвэрлэлтэд төмөр замын тээвэр томоохон байр суурь эзэлдэг. Төмөр замын тээвэр нь хуурай замын тээврийн төрөл хэлбэрүүдийн дотроос их хэмжээний ачааг харьцангуй богино хугацаанд, бага зардлаар тээвэрлэх боломжийг олгодгоороо давуутай юм. Гэхдээ төмөр замын тээвэр нь тусгайлан зассан замыг хэрэглэдэг, ачааг “хаалганаас хаалганд” хүргэж чаддаггүй зэрэг сул талуудтай. Түүнчлэн үйл ажиллагааны нарийн чанд технологийг шаарддаг, цаг хугацааны нарийвчилсан хуваарийн дагуу явагддаг.

Төмөр замын тээвэрлэлтийн давуу тал нь:

- ✚ Тээвэрлэлтийн явцад сэлгэн ачилт бага. Холын зайд их хэмжээний бараа тээвэрлэхэд тохиромжтой.
- ✚ Тээврийн зардал хямд.
- ✚ Бараа бүтээгдэхүүнийг хурдан хугацаанд тээвэрлэх боломжтой.
- ✚ Аюулгүй байдлыг сайн хангадаг.
- ✚ Цаг агаарын нөлөөлөл байхгүй.
- ✚ Агаарын бохирдолт бага, замын хувьд аюул багатай.
- ✚ Тээвэрлэх зай хол байх тусам тээврийн зардал багасна.

Төмөр замын тээвэрлэлтийн сул тал нь:

- ✚ Галт тэрэгний хуваарь зэрэг өөрийнх нь онцлогоос шалтгаалж цаг их шаардана.
- ✚ Үйлдвэрлэгчийн үйлдвэрээс шууд ачилт хийх боломж хязгаарлагдмал.
- ✚ Тусгайлсан зам чиглэлд л тээвэрлэлт хийдэг.
- ✚ Ачилт, буулгалт хийх цэг нь үйлдвэрлэгч эсхүл худалдан авагчаасалслагдсан байх нь түгээмэл.

Төмөр замын тээвэрт битүү вагон, хагас вагон, тавцант болон тусгай зориулалтын цистерн, бункер, танкер зэрэг вагоноор ачааг тээвэрлэхээс гадна цаг агаарын халуун, хүйтнээс хялбар муудах ачааг хөргүүртэй болон тогтмол дулаантай вагоноор, үнэ цэнэтэй ачааг харуул хамгаалалттай тээвэрлэх зэргээр тээвэрлэлтийн олон хэлбэрийг санал болгож чаддаг.

**Шалгуур үзүүлэлт** буюу индикатор гэдэг нь бидний хийж байгаа үйлдэл, үйл ажиллагааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж буй асуудал, удахгүй болох нөхцөл байдлын дохио, эрсдэл, үр дүнг хэмжиж байгаа хэмжээсүүд бөгөөд албан ёсоор ашиглахаар сонгогдсон мэдээллийн багц юм.

Шалгуур үзүүлэлтийг дараах түвшинд боловсруулдаг.

Зураг 8. Төмөр замын тогтвортой байдлыг хэмжих түвшин ба загвар



Хүснэгт 2. Төмөр замын салбарын тогтвортой байдлыг үнэлэх шалгуур хэмжүүрүүд /Indicator Framework for the Evaluation of Transport Sustainability Performance /

Нийгэм	Эдийн засаг	Хүрээлэн буй орчин
Орон нутагт хамаарах хүн ам	ДНБ-д салбарын эзлэх хувь	Ялгаруулж буй хий, CO2-ын хэмжээ
Жилд зорчсон зорчигчийн тоо	ДНБ эзлэх ажиллах хүчин	Төмөр замын дуу чимээний байдал
Салбарын боловсролын түвшин	Түлш шатахууны зардал	Хүлэмжийн хийг багасгасан ажлууд
Хүний нөөцийн эргэцийн хувь	Аюулгүй байдал- ослын түвшин	Хүн амын дунд төмөр замын үзүүлэх дуу чимээ, эрүүл мэндэд нөлөөлөх байдал
Салбарын ажиллагсдын цалингийн хувь	Нийт зардал	Ачаа ачилт, буулгалтын амьдарлын мөчлөг, хүрээлэн буй орчны үр нөлөө
Барьсан төмөр замын урт, хамаарах нутаг дэвсгэр	Техник-технологи	Байгалын нөөц баялаг
Дэд бүтэц барих систем	Боомтуудын боломж, эзлэх хувь, нас	Хүний нөөц-шууд ба шууд бус ажил олголт
Дэд бүтэц барьсан нийт зардлын эзлэх хувь	Жилийн тээвэрлэлт	Хатуу түлш боловсруулалт
Төмөр замын хүртээмжийн хувь	Нийт зүтгүүрийн моторын хэмжээ	Нөхөн сэргээгдэх ба холимог эрчим хүч ашиглалт
Тулгамдаж буй асуудал	Хөгжил дэвшил, инновацийн төсөлд эзлэх судалгааны хувь хэмжээ	1ж зорчигчид ногдох моторын хоосон жин

Хаалганаас-хаалга хүргэсэн хурд	Өндөр технологийн эдийн засгийн үр нөлөө	Төмөр замын дэд бүтэц, тээвэрлэлтийн системийн экологийн
---------------------------------	--	--

## ДҮГНЭЛТ

Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал 2030-д заасан төмөр замын салбарт I үе шатын хүрээнд дараах ажлууд хийгджээ.

**I үе шат (2016-2020): Замын-Үүд, Хөшигийн хөндий, Алтанбулагт тээвэр ложистикийн төв байгуулж, олон улсын болон улсын чанартай авто замын сүлжээн дэх хатуу хучилттай авто замын уртыг 1600 км-ээр нэмэгдүүлж, Ухаа худаг–Гашуун сухайт чиглэлийн төмөр замыг барьж ашиглах, Эрдэнэт–Овоот, Богд хаан төмөр замыг барьж байгуулах ажлыг эхлүүлэх, дамжин өнгөрөх тээврийг хөгжүүлэх зорилтын дагуу:**

- “МТЗ” ТӨХК нь Замын-Үүд дэх “Бүс нутгийн логистик төв”-ийг барьж, ашиглалтанд оруулсан. Замын – Үүд Логистикийн төв нь өргөн болон нарийн царигийн 11,6 км орчим төмөр зам, түвшинд огтлолцох хүнд даацын төмөр бетон гүүрэн байгууламж, 1,6 км авто зам, дэд бүтэц, барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ, нарийн болон өргөн царигийн ачилт буулгалтын 4 замтай, шилжүүлэн ачилт хийх зориулалттай 50 тн даацтай 2 вандан крантай нийт 128 га талбайг хамарсан шилжүүлэн ачилт болон логистикийн үйлчилгээ үзүүлэх цогц байгууламж юм. Уг байгууламжийн болон төмөр замын ачаа, тээврийн хэвийн, тасралтгүй үйл ажиллагааг хангах үүднээс “УБТЗ” ХНН-тэй 2016 оны 03 дугаар сарын 10-ны өдөр ТГ201626/02 дугаар бүхий түрээсийн гэрээг байгуулсан. 2016 оны 03 дугаар сарын 16-ны өдөр түрээсийн зүйл болох шилжүүлэн ачих байгууламж болон 2 чингэлэг өргөгч төхөөрөмж /калмар/-ийг акт үйлдэн хүлээлцэж “Шилжүүлэн ачих цогцолбор-1”-ийн үйл ажиллагааг “УБТЗ” ХНН-т түрээсийн гэрээний үндсэн дээр шилжүүлэн ажиллаж байна. Түрээсийн гэрээний хугацаа нь 2018 оны 03 дугаар сарын 10-ны өдрөөр дуусгавар болсон бөгөөд Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын даргын 2018.03.26 А-1/847 албан бичгээр уг гэрээний хугацааг гэрээний 6.2-д зааснаар сунгасанд тооцсон. 2023 оны 8 сар хүртэл түрээсийн гэрээг сунган ажиллаж байна.
- Тавантолгой-Гашуунсухайт чиглэлд 267 километр төмөр зам барьж байгуулах ажлыг Тавантолгой ХХК-ийн гүйцэтгэгчээр Боди Интернэшнал ХХК хариуцан гүйцэтгэж байна. Төмсөр замын барилгын ажлыг 2022 оны 7-р сард дуусган хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн байна.
- Эрдэнэ-Овоотын ажлыг эхлээгүй , Богд хаан төмөр замыг 2022 оноос барьж байгуулахаар төлөвлөсөн.
- Шинэ төмөр зам төслийн хүрээнд Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416 км төмөр замыг барьж 2022 оны 7-р сард хүлээлгэн өгөхөөр төлөвлөсөн. Өнөөдрийн байдлаар I үе шатны 4 төлөвлөсөн төмөр зам, логистикийн ажил 50 хувийн гүйцэтгэлтэй байна гэж дүгнэж байна. Судлаачын зүгээс дээрх олон улсын төмөр замын тогтвортой хөгжлийн хэмжих шалгуур үзүүлэлт дээр тулгуурлан үндэсний

онцлогт нийцүүлэн шалгуур үзүүлэлтийг тодорхойлж, цаашид Монгол улсад төмөр замын салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниуд дээр хэмжин, тогтвортой хөгжлийн түвшинг тодорхойлно.

Монгол Улсын тээвэр, логистикийн салбар улс орны эдийн засагт төдийгүй Монголын нийт хүн амын өдөр тутмын амьдралд амин чухал үүрэг гүйцэтгэдэг. Тус улсын эдийн засгийн үндсэн хөдөлгөгч хүч бол эрдэс баялаг юм. Монголын эрдэс бүтээгдэхүүний экспортын олон улсын зах зээл дээрх өрсөлдөх чадвар тус улсын логистик, тээврийн чадвараас хамаарна. Хил дамнасан тээвэр, логистикийн тогтолцоо бүтээмж сайтай байх нь худалдаа өсөн тэлэх суурь болдог.

Трансмонголын төмөр зам бол тус улсын газар нутгаар зоригч болон ачаа тээвэрлэдэг үндсэн артерийн шугам хэдий ч тус улсын маш багахан хэсэгт хүрч үйлчилж байна. Үүний учир авто замаас ихээхэн хамааралтай болж, тус улсын эрдэс бүтээгдэхүүний экспортын дийлэнх нь төмөр замгүйн улмаас авто замаар тээвэрлэгдэж байна. Монгол Улсын тээвэр, логистикийн үнэ өртөг өндөр байна. Азийн хөгжлийн банкны 2018 онд хийсэн судалгаагаар бараа бүтээгдэхүүний үнийн 30 орчим хувийг тээвэр, логистикийн зардал эзэлж байгаа нь бусад улс оронтой харьцуулахад ихээхэн өндөр үзүүлэлт юм. Оросын Холбооны Улс, БНХАУ зэрэг хөрш зэргэлдээ улсаас хамааралтайн улмаас тодорхой хүндрэл бэрхшээл тулгарч байгаа ч, үнэ өртөг өндөр байгаагийн шалтгааны нэг нь Монгол Улс дахь тээвэр, логистикийн экосистемийн хөгжлийн дорой байдал юм. Энэхүү судалгаагаар төмөр замын тээврийн салбарт тулгарч буй асуудлуудыг хэлэлцэж, тэдгээрийг шийдвэрлэх тодорхой аргачлал, зөвлөмжүүдийг Азийн хөгжлийн банкны хийсэн судалгаагаар гаргасан саналыг танилцуулж байна.

1. Монгол Улсын импортод чингэлэг ачаа тээвэр давамгайлдаг. Холимог ачаа тээврийн төв байгуулах /Замын үүдийн логистикийн төвийг өргөтгөх/
2. Уурхай, хилийн боомтуудыг төмөр замаар холбох. Шинэ сэргэлтийн бодлогоор 2022 онд 4 боомтыг төмөр замаар холбоно.
3. Хилийн боомт дээрх цариг солих ажлыг механикжуулах-Шинэ сэргэлтийн бодлогоор-Гашуунсухайт, Ханги, Бичигт, Сэхэ боомтуудын нарийн цариг солих ажлыг эхлүүлэх. Мөн дүүжин тээвэр буюу агаарын чингэлэг тээврийг барихаар зорьж байна.
4. Дотоодын төмөр замын сүлжээг өргөжүүлэх-Даланзадгад-Тавантолгой, Зүүнбаян-Баруунхараа чиглэлд төмөр зам барих ажлыг “МТЗ”ТӨХК-д даалгасан.
5. Тогтвортой хөгжлийн III үе шатны ажил болох баруун, зүүн бүсийн төмөр зам барих ажлыг 2022 оны 3-р сарын 16-ны өдрийн 116 дугаар тогтоолоор “МТЗ”ТӨХК-д даалгаж, ТЭЗҮ дээр тодотгол хийгдэж байна.

### НОМ ЗҮЙ

1. Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэхэд нөлөөлөх субъектив хүчин зүйлсийн шинжилгээ. (2019). Шинжлэх Ухааны Академийн Философийн хүрээлэн. Улаанбаатар хот.
2. Даш-Ёндон. Б (Sci.D). Хөгжихүйн философи. (2019) Улаанбаатар хот
3. Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030.(2015)

4. Үндэсний Хөгжлийн Газар. (2018). Монгол Улсын хөгжлийн бодлогын тогтвортой байдал, залгамж чанар, уялдаанд хийсэн шинжилгээ. Тайлан1.
5. Сүхбаатар.Ц. (2018). Хөгжлийн эдийн засаг. Улаанбаатар.
6. Батхүрэл.Г. (2011). Монголын эдийн засгийн удирдлагын сэтгэлгээний хөгжлийн судалгаа (онол үзэл баримтлал, чиг хандлага).УБ.
7. БОАЖЯ.ТХБ төсөл. (2018). Тогтвортой хөгжил, ногоон хөгжил, тогтвортой хөгжлийн боловсрол.УБ
8. ОУ-ын Эко аюулгүйн оршихуйн Хамтын ажиллагааны байгууллага. (2012). Эко аюулгүйн оршихуйн үндсэн асуудлууд.
9. UN and Deloitte Consulting LLP (2010). Framework for Implementation.
10. European Commission.(2009) Indicators to Assess Sustainability of Transport Activities
11. CAREC. (2021) Railway sector assessment for Mongolia.
12. Алсын хараа-2050. 2018 он
13. Төрөөс төмөр замын талаар баримтлах бодлого. 2010 он
14. Азийн хөгжлийн банк. (2018). Саад тотгорыг арилгах нь. Монгол улсын тээвэр, логистикийн салбарын хөгжлийн тухай